

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 3 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 03 дугаар сарын 18		Улаанбаатар хот		
Дүд	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
Үүрэг, даалгавар НЭГ: Зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх.				
1	Чингэлтэй дүүргийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажил төлөвлөгөөний дагуу нийт 107 төсөл арга хэмжээ батлагдсанаас 28 ажлын тендер сонгон шалгаруулалт зарлагдсан. Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэстэй хамтран шууд худалдан авалтын зургийн ажлын даалгаврыг боловсруулж багцтай нээлттэй тендер шалгаруулалт болгон зарлахаар бэлтгэж байна.			30
Үүрэг, даалгавар ХОЁР: Тендер шалгаруулалтыг 3 болон түүнээс дээш удаа зохион байгуулаад амжилтгүй болсон төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж танилцуулах.				
2	2025 онд зарлагдсан нийт ажлаас одоогоор 3 болон түүнээс дээш зарлагдсан амжилтгүй болсон тендер сонгон шалгаруулалт байхгүй. Нээлттэй тендер сонгон шалгаруулалтад оролцсон шалгараагүй оролцогчдод дэлгэрэнгүй тайлбар мэдээлэл тухай бүрт хүргүүлэн ажиллаж байна.2024-2025 онуудад он дамжин хэрэгжүүлэх 33 Төсөл арга хэмжээнээс ажлын тоо хэмжээ даалгавар бүрэн Нээлттэй болон харьцуулалтын үнийн аргаар 4 тендер шалгаруулалтыг зохион байгуулж оролцогчдыг үнэлж , мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна.			90
Үүрэг, даалгавар ГУРАВ: Хөрөнгө оруулалтын ажлын эрхийг шилжүүлж авсан байгууллагууд дараагийн Шуурхай зөвлөгөөн дээр худалдан авах ажиллагааны явцыг танилцуулах.				
3	Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд нийслэлийн Засаг даргаас эрх шилжиж ирсэн 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд: 1. Чингэлтэй дүүргийн Нутгийн захиргааны байрны барилга барих нээлттэй тендер зарлагдсан. 2. Чингэлтэй дүүргийн нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадын засварын төсөл, арга хэмжээг зарлуулахаар Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс болон Худалдан авах ажиллагааны алба хамтран ажиллаж байна.			30

	3. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангаас эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ болох Чингэлтэй дүүргийн боловсрол болон эрүүл мэндийн салбарын барилгын засварын ажлын эрэмбэлсэн сонголт хийхээр Чингэлтэй дүүргийн боловсролын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, нийслэлийн Боловсролын газар, нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран ажиллаж байна.			
	Үүрэг, даалгавар АРАВ: Үлдэгдэл давс, бодисыг зориулалтын битүү дээвэртэй, стандартын шаардлага хангасан байранд нөөцөлж хадгалах ажлыг зохион байгуулах.			
4	Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар нийт 1474.5 тонн тусгай зориулалтын бодис, 486 м3 дайргын нөөцтэй байна. Хот нийтийн аж ахуйн чиглэлээр ажиллаж буй дүүргийн "Чингэлтэй тохижилт үйлчилгээ" ХХК, "Найши трейд" ХХК-иуд тус бүр өөрсдийн авто бааз, авто гарааштай ба үлдэгдэл давс, бодис дайргыг стандарт шаардлагын дагуу хадгалж байна.			100
	Үүрэг, даалгавар АРВАН НЭГ: Инженерийн шугам, сүлжээний засвар, шинэчлэлийн талаар дараагийн Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах.			
5	Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2025 онд инженерийн шугам, сүлжээний нийт 16 засварын ажил хийгдсэн. Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөр тус дүүргийн 6 дугаар хороо, 44-р байрны "Цахилгааны дотор салбар шугам засвар"-ын ажил, "Гол магистрал шугам засвар"-ын ажлыг "Роуд дэвэллопмент" ХХК-иар тус тус хийж гүйцэтгүүлсэн.			90
	Үүрэг, даалгавар АРВАН ЕС: Нийслэлийн төсвийн тодотголоос өмнө сургууль, цэцэрлэгүүдийн хөрөнгө оруулалтын асуудлыг эцэслэн шийдвэрлэх.			
6	Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дэх сургууль, цэцэрлэгүүдээс хөрөнгө оруулалтын саналыг хүлээн авч, төсвийн тодотголд суулгахаар нэгтгэн ажиллаж байна.			30
	Үүрэг, даалгавар ХОРИН ЗУРГАА: Хөрөнгө оруулалтаар шинэчилсэн хот нийтийн аж ахуйн машин тоног төхөөрөмжийн ашиглалтын асуудлаар санал, гомдлоо нэгтгэн танилцуулах.			
7	Чингэлтэй дүүрэг Хөрөнгө оруулалтаар шинэчилсэн хот нийтийн аж ахуйн машин тоног төхөөрөмж хүлээж аваагүй болно.			-
	ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ			61.6%

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ж.ЛХАГВАСҮРЭН

НЭГТГЭЛИЙГ ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ЦЭРЭННАМЖИЛ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.БУЯН-ӨЛЗИЙ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ШУУРХАЙН БИЕЛЭЛТ,
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ц.БАЛЖИННЯМ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

В.УРАНЧИМЭГ